



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/17

Улаанбаатар хот

Улаанбурхан, улаанууд өвчний эсрэг
вакцинаар нэмэлт дархлаажуулалт зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2026 оны А/21 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн хэмжээнд Улаанбурхан, улаанууд өвчний эсрэг нэмэлт дархлаажуулалтыг 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн зохион байгуулсугай.

2. Нэмэлт дархлаажуулалт зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. Нэмэлт дархлаажуулалтад хамрагдах хүүхдийн судалгааг зааварчилгааны дагуу гарган бүрэн хамруулж, иргэдэд дархлаажуулалтын ач холбогдлын талаар мэдээлэл хүргэж ажиллахыг Эрүүл мэндийн төв (Х.Ганбат), хороодын засаг дарга (Н.Нямзав, Б.Батзориг)-д тус тус үүрэг болгосугай.


4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 01 сарын 23 -ны өдрийн 417 дугаар
нэгдүгээр захирамжийн хавсралт



НЭМЭЛТ ДАРХЛААЖУУЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН
БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Цогжавхлан	Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
Гишүүд:	Х.Ганбат	Эрүүл мэндийн төвийн дарга
	Н.Нямзав	1 дүгээр хорооны Засаг дарга
	Б.Батзориг	2 дугаар хорооны Засаг дарга
	С.Болормаа	91 дүгээр сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Э.Болормаа	94 дүгээр сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Нарийн бичгийн дарга:	Э.Мянганбаяр	Хүүхдийн эмч